



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/54


Өлгий

Хоолны зардал гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/99 дүгээр тушаалаар баталсан "Байгууллагын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136.4 дэх хэсгийн 136.4.2-ын "в", мөн даргын 2013 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн "Хүнсний хангалтын тухай" 218 дугаартай тушаал, 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн "Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлэн ажиллуулах тухай" Б/559 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үеэр өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлсэнтэй холбогдуулан албаны бэлэн байдлыг хангах зорилгоор хавсралтанд заагдсан нэр бүхий 40 /дөчин/ алба хаагчид 1 /нэг/ хоногийн хоолны зардлыг 5000 /таван мянга/ төгрөгөөр тооцож, 3 /гурван/ хоногийн хоолны мөнгийг олгосугай.
2. Алба хаагч нарын хоолны мөнгө болох 600.000 /зургаан зуун мянга/ төгрөгийг хоол, хүнсний зардлаас зохих журмын дагуу бодож гаргахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн дэслэгч Б.Батсүх/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Т.Ганбат /-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



М.БАТБОЛД

00418